

“ХАРХОРИН” НЭЭЛТТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 04 дүгээр сарын 23 өдөр

Дугаар 01

Хархорин сум

*Компанийн 2021 оны үйл ажиллагаа болон
санхүүгийн тайлантай холбогдуулан
ТУЗ-аас гаргасан дүгнэлтүүдийг батлах тухай*

“Хархорин” Нээлттэй Хувьцаат Компанийн хувьцаа эзэмшигчдийн 2022 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9-г удирдлага болгон ТОГТООХ нь:

1. Компанийн 2021 оны жилийн үйл ажиллагааны талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг хангалттай хэмээн үзсүгэй.
2. Компанийн 2021 оны жилийн санхүүгийн тайлангийн тухай Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг хангалттай хэмээн үзсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



П.УЧРАЛ

“ХАРХОРИН” НЭЭЛТТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 04 дүгээр сарын 23 өдөр

Дугаар 02

Хархорин сум

*Ногдол ашигтай холбогдуулан
ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг батлах тухай*

“Хархорин” Нээлттэй Хувьцаат Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 02 дугаар сарын 18-ний өдрийн 04/2022 тоот тогтоол, Хувьцаа эзэмшигчдийн 2022 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын шийдвэрийг тус тус үндэслэн, Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.6-г удирдлага болгон ТОГТООХ нь:

“Хархорин” Нээлттэй Хувьцаат Компани нь 2021 оны жилийн эцсийн аудитлагдсан санхүүгийн тайлангийн дагуу нийт 43,059.3 мянган төгрөгийн татварын дараах алдагдалтай ажилласантай холбогдуулан 2022 онд ногдол ашиг хуваарилахгүй тухай Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан шийдвэрийг зөвшөөрсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



П.УЧРАЛ

“ХАРХОРИН” НЭЭЛТТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 04 дүгээр сарын 23 өдөр

Дугаар 03

Хархорин сум

*Төлөөлөн удирдах зөвлөлийн
гишүүдийн бүрэн эрхийн тухай*

“Хархорин” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2022 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ нь:

“Хархорин” нээлттэй хувьцаат компанийн 2021 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 04 дүгээр тогтоолоор сонгогдсон Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгохоор тогтоосугай.

ХУРЛЫН ДАРГА



П.УЧРАЛ

“ХАРХОРИН” НЭЭЛТТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 04 дүгээр сарын 23 өдөр

Дугаар 04

Хархорин сум

*Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон
хараат бус гишүүдийг томилох тухай*

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7-г удирдлага болгон “Хархорин” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2022 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “Хархорин” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүдээр
 - ✓ Сандагийн АМГАЛАН,
 - ✓ Баатарын АМАРСАНАА,
 - ✓ Баттулгын БҮРЭН нарыг томилсугай.
2. “Хархорин” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүдээр
 - ✓ Пүрэвийн БИШРЭЛ,
 - ✓ Пүрэвийн УЧРАЛ,
 - ✓ Жаргалын ЭНХТӨР,
 - ✓ Лхагвасүрэнгийн БАЯРТУЛГА,
 - ✓ Цэрэндолгорын ЭНХ-АМГАЛАН,
 - ✓ Ойдовсүрэнгийн ТӨМӨРБААТАР нарыг томилсугай.

ХУРЛЫН ДАРГА



П.УЧРАЛ